НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

# Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн төслийн зардлын шинжилгээ

СУДЛААЧ А.МӨНХЦОГ /сэзис/

2019 ОНЫ 10 САР

# Төсвийн танилцуулга




*Манай улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 88.7 хувь буюу 8,585.8 тэрбум төгрөгийг 2019 онд татварын орлогоор бүрдүүлнэ. Үүний 19.8 хувийг нийгмийн даатгалын орлого эзэлж байна.*

# Төсвийн танилцуулга



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО




сайн дурын даатгуулагчдын хураамжийн орлогыг 30 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 97,1 тэрбум төгрөг буюу 2018 оны түвшнээс **45.3%** өсгөж төсөвлөсөн нь хэт өөдрөг төсөөлөл

2019 онд албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 320.0 гаруй мянган иргэдийн 64.8 хувь буюу 207.2 орчим мянган хүн сайн дурын даатгалд хамрагдахаар тооцсон байгаа нь 2018 оны төсвийн төсөлд туссан үзүүлэлтээс **30.5 мянган хүнээр** бага үзүүлэлт байна.

Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлснээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 2019 онд 70.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцоолсон байна.

*1.2.Тэтгэврийн шинэчлэлийн бодлого нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан тусгай хөтөлбөрийг бий болгож, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна*
***/ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030//***

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА




Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 90%-ийг тэтгэврийн даатгал

2019 оны нийгмийн даатгалын сангийн орлого нь зөвхөн тэтгэврийн даатгалын сангийн зарлагынхаа **86%-ийг** нөхөж байна**.**

өндөр настны тэтгэвэрт нийгмийн даатгалын сангийн орлогын 88%-ийг зарцуулах

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АЛДАГДАЛ




Нийгмийн даатгалын сангийн цэвэр алдагдлын хэмжээ 2019 онд ДНБ-ий 1.3%-тай, сангийн орлогын 29%-тай тэнцэж байна

2015 оноос хойш алдагдлын ДНБ-д эзлэх хувь дунджаар 1.6% байсаар байна.

Тэтгэврийн даатгалын сан 601.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа ба энэ нь нийгмийн даатгалын сангийн нийт орлогын **37.5%**-тай тэнцэж байна

*Өнөөгийн манай нийгмийн даатгалын сангийн тогтолцоо нь "Хуваарилалтын хэлбэртэй" буюу даатгуулагчдаас шимтгэл хураан авч тухайн үед тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэвэрт шууд зарцуулах замаар залуу үеийнхний шимтгэлийн орлогоор ахмад үеийнхний тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх аргаар явагдаж байгаа хэдий ч орлого нь зарлагаа нөхөж чадахгүй байна.*

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АЛДАГДАЛ




Нийгмийн даатгалын сангийн цэвэр алдагдлын хэмжээ 2019 онд ДНБ-ий 1.3%-тай, сангийн орлогын 29%-тай тэнцэж байна

2015 оноос хойш алдагдлын ДНБ-д эзлэх хувь дунджаар 1.6% байсаар байна.

Тэтгэврийн даатгалын сан 601.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа ба энэ нь нийгмийн даатгалын сангийн нийт орлогын **37.5%**-тай тэнцэж байна

*Өнөөгийн манай нийгмийн даатгалын сангийн тогтолцоо нь “Хуваарилалтын хэлбэртэй” буюу даатгуулагчдаас шимтгэл хураан авч тухайн үед тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэвэрт шууд зарцуулах замаар залуу үеийнхний шимтгэлийн орлогоор ахмад үеийнхний тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх аргаар явагдаж байгаа хэдий ч орлого нь зарлагаа нөхөж чадахгүй байна.*

# ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА




*Бүх тэтгэврийн хэмжээг 27.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээ 251.0 мянган төгрөгөөс 280.0 мянган төгрөгт хүрч 11.6 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 216.0 мянган төгрөгөөс 243.0 мянган төгрөгт хүрч 12.5 хувиар тус тус нэмэгдүүлсэн.*

2019 онд нийт 439.9 мянган хүний тэтгэвэрт хамрагдахаар тусгагдсан. (+23 мянган хүн)

Алдагдлыг хэмжээ сүүлийн жилүүдэд сангийн орлогын 60-аас дээш хувьтай тэнцүү байгаа нь /2017 онд 61%, 2018 онд 60%, 2019 оны төсөвт 48%/ анхаарал татах асуудал болж байна

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхээр баталсантай холбоотойгоор тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 2019 онд **70.2 тэрбум төгрөгөөр** нэмэгдэнэ

*Нэг ажилтны төлөх дундаж шимтгэлийн хэмжээ 40 орчим мянган төгрөгөөр нэмэгдэнэ.*

*2.1.6.тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагыг тэнцвэржүүлж, сангийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтрүүлэхгүй байх; /* ***ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030//***

# ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдалын сангийн орлогод эзлэх хувь, өндөр настны тэтгэврийн сангийн орлогод эзлэх хувь 2011-2019




Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд нь нийгмийн даатгалын сангийн зарлагыг 2019 онд 81.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үр дагавартай байна гэж үзэж хуулийн үйлчлэлийг 2020 оноос хэрэгжүүлж эхлэхээр хойшлуулсан байна

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн хэрэгжилтийг мөн 2 жилээр хойшлуулж 2021 оноос хэрэгжиж эхлэхээр хойшлуулсан

*3.2.14.2030 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх; /**ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030//***

# ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА




Өндөр настны тэтгэврийн зарцуулалт нь дунджаар тэтгэврийн даатгалын сангийн зарлагын 70-аас дээш хувийг сүүлийн 8 жилд эзлэж байгаа ба жилээс жилд нэмэгдэж 2011 онд 72.96%

2017 онд 75.18%,

2018 оны батлагдсан төсөвт 75.76%,

2019 оны төсөвт 76.12%-ийг эзлэж байна.

# ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

*Тэтгэмжийн даатгалын сангийн орлого зарлага 2011-2019*




Тэтгэмжийн даатгалын сангийн орлого сүүлийн 8 жилд дунджаар 23,3% өссөн бол сангийн зарлага дунджаар 17,8% өссөн байна.



# ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

| | 2018 | | | 2019 | | | Нэг хүнд ногдох тэтгэмжийн өсөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Мөнгөн дүн /тэрбум төгрөг/ | Нэг хүнд оногдох дундаж | Хүний тоо | Мөнгөн дүн /тэрбум төгрөг/ | Нэг хүнд оногдох дундаж | |
| **Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж** | 131.7 | 17.2 | 130,600 | 133 | 18.7 | 140,602 | 10,002 |
| **Жирэмсний болон амаржсаны тэтгэмж** | 60.1 | 71.7 | 1,193,012 | 60.7 | 86.6 | 1,426,689 | 233,677 |
| **Оршуулгын тэтгэмж** | 13.4 | 13.4 | 1,000,000 | 13.4 | 13.4 | 1,000,000 | - |

# Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (ҮОМШӨ)-ий даатгалын сангийн зарлага




ҮОМШӨ-ий даатгалын сангийн орлого өнгөрсөн 2011-2018 онуудад дунджаар 17% өсч байсан бол 2019 онд орлогын хэмжээ 19,9% өсч төсөвлөгдсөн байна. Тус сангийн зарлагын хэмжээ орлогынхоо 34,3% дунджаар эзлэж байна




ҮОМШӨ-ийн тэтгэмжийн зарлагад жилд дунджаар тогмол 24 гаруй тэрбум төгрөг зарцуулдаг

# Ажилгүйдлийн даатгалын сан

- Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын 98-99 хувийг ажилгүйдлийн тэтгэмжийн зардал эзлэж байна.

- 2019 онд 36.6 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулахаар төсөвлөсөн ба энэ нь нэг иргэнд 1.7 сая төгрөгийн тэтгэмж олгохоор төсөвлөгдсөн байна. Энэ нь өмнөх оны батлагдсан төсвөөс 3.8% өссөн үзүүлэлт юм.

- 2019 онд ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийн тоо 21.3 мянган иргэнээр тооцоолж байгаа бол энэ тоо 2018 оны төсөвт 25.1 мянган иргэн, 2017 онд 22.1 мянган иргэн байхаар төсөвлөж байжээ.

- Мэргэжил олгох давтан сургалтын зардалд 2017, 2018, 2019 онуудад ижил 96 сая төгрөг төсөвлөсөн ба 2017 оны гүйцэтгэлээр 1.1 сая төгрөг зарцуулсан байна.

*3.2.14.2030 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх; /**ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030//***

# ДҮГНЭЛТ

## ОРЛОГО

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлогыг 2019 онд **70.2 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлэх / Нэг ажилтны төлөх дундаж шимтгэлийн хэмжээ 40 орчим мянган төгрөгөөр нэмэгдэнэ/

## ЗАРЛАГА

- Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх замаар нийт **119.5 тэрбум төгрөг** нэмж тусгасан ба үүний 73%-ийг өндөр настны тэтгэврийн нэмэгдэл, 18%-ийг тахир дутуугийн тэтгэврийн нэмэгдэл эзэлж байна.

***ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТТЭЙ ХОЛБООТОЙГООР НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДАХ ДААТГУУЛАГЧДЫН ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, БОЛОМЖИТ БУСАД ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГО БАРИМТАЛНА /ЗАСГИЙН ГАЗАР/***

ИРЭЭДҮЙН ТЭТГЭВЭР ТОГТООЛОГЧДОД ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН БАТАЛГАА БҮРДЭХГҮЙ БАЙНА.